

# “ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр

№ТУЗТ 12/2022

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

“Erdenes America” LLC охин компанийн хувь  
нийлүүлсэн хөрөнгө тогтоох, Сургалтын төлбөр  
төлөх, Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 55 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.8, 76.1.17, 76.2 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.6, 9.10.7, 9.10.14, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2022 оны 06-р сарын 06-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын Делавер мужид үүсгэн байгуулсан “Erdenes America” LLC компанийн энгийн хувьцааг 1 (нэг) бүр нь 1 (нэг) ам долларын нэрлэсэн үнэтэй 100'000 (нэг зуун мянга) ам долларын нийт 100'000 (нэг зуун мянга) ам долларын хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байхаар тогтоосугай.
2. Компани Америкийн нэгдсэн улсын арилжааны банкинд данс нээж холбогдох мөнгөн хөрөнгө оруулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хуяг)-т даалгасугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигч Б.Батхүүгийн охин Б.Ариунтуяа (РД:УХ04281947)-ийн Америкийн нэгдсэн улсын Сизтл хотын Seattle University-ийн Computer Science мэргэжлээр суралцах сургалтын болон ном сурах бичгийн зардалд жил бүр 30'600 (гучин мянга зургаан зуу) ам доллар, амьдрах зардалд 14 (арван дөрвөн мянга) ам доллар нийтдээ 44'600 (дөчин дөрвөн мянга зургаан зуу) ам долларыг 4 (дөрөв)-н жилийн турш нийт 178'400 (нэг зуун далан найман мянга дөрвөн зуу) ам долларыг зээлээр санхүүжүүлсүгэй.
4. Б.Ариунтуяагийн сургалтын болон амьдрах зардалд зарцуулж буй 178'400 (нэг зуун далан найман мянга дөрвөн зуу) ам долларын сургалтын зээлийн барьцаанд хувьцаа эзэмшигч Б.Батхүүгийн ээж Г.Дулмаагийн нэр дээр буй компанийн 1 (нэг) ширхэг бүр нь 108 (нэг зуун найм) төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй 9'000'000 (есөн сая) ширхэг буюу өнөөдрийн үнэлгээгээр 972'000'000 (есөн зуун далан хоёр сая) төгрөгийн буюу 303'000 (гурван зуун гурван мянга) ам долларын үнэлгээ бүхий энгийн хувьцааг барьцаалсан сургалтын зээлийн гэрээ хийхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д зөвшөөрсүгэй.
5. Б.Ариунтуяа нь Сизтл хотын Seattle University-ийн Computer Science мэргэжлээр амжилттай суралцаж төгсөн Компанид 6 (зургаа)-н жил ажилласан тохиолдолд ажилласан нийт жил, сараас хамаарч сургалтын зээлээс бүрэн чөлөөлөх заалт хувьцаа барьцаалсан сургалтын зээлийн гэрээнд тусгахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Г.ЗОЛБОО/